



**НИЙСЛЭЛИЙН  
АГААРЫН БОХИРДОЛТОЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 06 сарын 16 өдөр

Дугаар А/50

Улаанбаатар хот

┌  
Эд хөрөнгийн тооллого хийх  
комисс байгуулах тухай  
└

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үндсэн болон хангамжийн хөрөнгийн тооллогыг 2021 оны хагас жилийн байдлаар явуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Г.Даваажаргал	Агаарын чанар, хяналт, зохион байгуулалтын хэлтсийн дарга
Гишүүд:	М.Отгонбаяр	Хөдөлгөөнт эх үүсвэрийн хэмжилт хариуцсан ахлах мэргэжилтэн
	Т.Энхмаа	Хяналт, шинжилгээ үнэлгээ, хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн
	Ч.Нэргүй	Агаарын чанарын хяналт хариуцсан мэргэжилтэн
	А.Даваахүү	Диспетчер
Нарийн бичгийн дарга:	Э.Энх-Амгалан	Агаар бохирдуулах суурин эх үүсвэрийн хэмжилт хариуцсан мэргэжилтэн

2. Эд хөрөнгийн тооллогыг 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 2021 оны 06 дугаар сарын 28-ныг хүртэл хугацаанд үнэн зөв зохион байгуулж, илтгэх хуудаст тусган 2021 оны 06 дугаар сарын 30-ны дотор Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 73 дугаар зүйл Эд хөрөнгийн тооллого явуулах журамд заасны дагуу танилцуулахыг комиссын дарга (Г. Даваажаргал)-д үүрэг болгосугай.


3. Тооллогоор цаашид ашиглах боломжгүй болсон эргэлтийн бус хөрөнгийн жагсаалтыг гаргаж холбогдох баримтыг бүрдүүлэн Нийслэлийн Өмчийн ашиглалт,

Ahta/tushaal 2021/

1150500045

удирдлагын газраар шийдвэр гаргуулах, эргэлтийн хөрөнгийг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлөөр шийдвэрлүүлэн данс бүртгэлээс хасахыг тооллогын комиссын дарга, өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга нарт даалгасугай.

ДАРГЫН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ПҮРЭВСҮРЭН